



БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2026 он

ГАНЦ МОДГАЛ БОЛДОГҮЙ

Ганц мод гал болдоггүй

Банкны салбарын үзүүлэлт тогтвортой, өсөлттэй байлаа. Банкны салбарын нийт актив өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20 хувиар нэмэгджээ. Чанаргүй зээлийн хэмжээ сүүлийн 15 жилийн доод хэмжээнд хүрлээ. Банкнуудын өөрийн хөрөнгийн өгөөж хадгаламжийн өгөөжөөс өндөр байна. Эдийн засгийн салбаруудыг дэмжихэд чиглэсэн банкны зээлийн өсөлт үргэлжилсээр байна.

Инфляцын түвшин буулгахад чиглэсэн бодлогын арга хэмжээний нөлөөгөөр инфляц харьцангуй тогтвортойгоор буурч байна.

Урсгал дансны алдагдал буурч аялал, жуулчлалаас олох орлого нэмэгдсэн, тэр дундаа санхүүгийн данс ашигтай гарсан нь валютын нөөцийг нэмэгдүүлж, төгрөгийн худалдан авах чадвар тогтвортой байхад чухал нөлөө үзүүлээ. Уул уурхайн гол бүтээгдэхүүн болох нүүрсний үнийн бууралтаас шалтгаалан экспортын орлого буурсан хэдий ч зэс, алтны үнийн өсөлт өндөр байсан цэвэр экспорт эерэг гарахад чухал нөлөө үзүүлээ.

Цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалж хүндрээд байсан хөдөө аж ахуйн салбар сэргэсэн нь эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө үзүүлээ. Уул уурхайн салбар болон түүнийг дагасан тээвэр, логистикийн салбарын өсөлт тогтвортой, үйлчилгээ болон худалдааны салбарын өсөлт үргэлжилсэн нь эдийн засаг 6.8 хувиар өсөхөд чухал нөлөө үзүүлсэн.

Уул уурхайн гаралтай эрдэс бүтээгдэхүүн тэр дундаа нүүрсний үнийн болон тоон хэмжээний өсөлтөд найдан эдийн засгийн өсөлтийг өндөр байхаар төлөвлөж, төсвийн зарлагыг нэмэгдүүлэх нь ганц мод гал болдоггүйтэй адил хэтэрхий өрөөсгөл байна. Иймд уул уурхайн эрдэс бүтээгдэхүүний төрөлжилтөөс эхлээд бусад салбаруудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг анхаарахад ихээхэн анхаарал хандуулах шаардлагатай болох нь харагдаж байна.




Иргэдийн хэрэглээний зээл олголт саарчээ.

Өр орлогын харьцаанд өөрчлөлт орсон нь цалин, тэтгэврийн зээл буурахад нөлөөлжээ. Хадгаламж барьцаалсан болон кредит картын зээл илүү өсөлттэй байна.

Онцлох өөрчлөлт,
энгийн тайлбар

Иргэдийн зээл олголт, жил бүрийн эцэст



Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

Онолын тодорхойлолт

Шинээр иргэдэд олгосон зээлийн хэмжээ нэмэгдэв.

9%

2025 оны жилийн
эцсийн гүйцэтгэл

2025 ОНД БАНКНЫ САЛБАРТ ГАРСАН ОНЦЛОХ ӨӨРЧЛӨЛТ, ЦААШДЫН ХАНДЛАГА



Банкуудын бизнесийн зээл олголт нэмэгдэж эдийн засгийн салбаруудын өсөлтийг дэмжиж байна.



Банкуудын чанаргүй зээл сүүлийн 15 жилийн доод хэмжээнд ирлээ.



Банкуудын өөрийн хөрөнгөөр бий болгосон ашиг өндөр хэвээр байна.



Системийн нөлөө бүхий 5 банкны санхүүгийн үзүүлэлт өсөлттэй байна.



Системийн нөлөө бүхий банкны хувьцааг 77,169 жижиг хувьцаа эзэмшигчид худалдан авчээ.



Эдийн засгийн тодорхой бус байдлаас шалтгаалан иргэд хугацаатай хадгаламжид итгэх итгэл нэмэгджээ.

БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2025 он

Банкны салбарын зээлийн өсөлт удааширч байна.

Бодлогын хүү өндөр байгаа ч банкуудын зээл олголт өсөлттэй байна.

Эдийн засгийн идэвхжилд банкны салбарын бизнесүүдэд чиглэсэн зээл олголт чухал нөлөө үзүүлж байна.

Банкны зээлийн багц


Жич: Зээлийн үлдэгдэл нь шинээр олгосон зээлээр нэмэгдэж, эргэн төлөлтөөр буурч байдаг.

Зээлийн үлдэгдэл

19%

ӨСӨВ.

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо




Эдийн засгийн бодит салбарыг дэмжихэд чиглэсэн зээл олголт өсөлттэй байна.

Худалдаа, үйлчилгээний салбарт олгож буй зээлийн өсөлт үргэлжилж байна.
Уул уурхай, барилга, боловсруулах салбарыг дэмжихэд чиглэсэн зээл олголт өсөлттэй байна.

Бизнесийн зээл олголт, жил бүрийн эцэст

Тэрбум ₮



Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

Бизнесийн зээлийн олголт

20%

НЭМЭГДЭВ.

Банкны зээлийн чанар

Жич: 90 хоногоос дээш хугацаагаар зээлээ төлөөгүй нөхцөлд чанаргүй зээлд шилждэг.

Салбарын хэмжээнд
чанаргүй зээл буурчээ.

5%


Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо

Чанаргүй зээлийн хэмжээ сүүлийн 15 жилийн түүхэн доод түвшинд байна.


Иргэдийн хэрэглээний 10 зээл тутмын 1 нь чанаргүй байна.

Эдийн засгийн салбаруудад олгосон зээлийн чанаргүйдэл буурчээ.

Иргэдийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн эцэст



Бизнесийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн эцэст



Банкны жигнэсэн дундаж хүү


Жич: Банкуудын шинээр татсан эх үүсвэрийн хүү, олгосон зээлийн хүү нь цаг хугацаа, мөнгөн дүнгийн хувьд жинлэгдсэн дундаж хүүг хэлнэ.

Хадгаламжийн хүү

12%

Хүүгийн түвшин харьцангуй тогтвортой байна.


Төв банкнаас бодлогын хүүг нэмэгдүүлсэн хэдий ч зээлийн хүү харьцангуй тогтвортой байна. Хадгаламжийн хүү аажмаар нэмэгдэж байна.



Тодорхой бус байдал нэмэгдсэнтэй холбоотойгоор иргэд илүү хугацаатай хадгаламжид хөрөнгөө байршуулжээ.

Төгрөгийн ханш харьцангуй тогтвортой, инфляц аажмаар буурсан нь төгрөгт итгэх итгэлийг нэмэгдүүлжээ.
Төгрөг, валютын хадгаламж 18 хувиар нэмэгджээ.
Валютын харилцах 14 хувиар, төгрөгийн харилцах 4 хувиар тус тус буурчээ.

Банкны эх үүсвэр, жил бүрийн эцэст



Банкны эх үүсвэр

Жич: Энэ нь банкны татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийг хэлдэг.

Банкны эх үүсвэр

8.7%

нэмэгджээ.

Банкны системийн долларжилт

Жич: Хадгаламж болон зээлийн хэдэн хувийг валютын
эх үүсвэр болон зээл бүрдүүлж байгаагаар
тодорхойлогддог.

Эх үүсвэрийн долларжилт


21%

байна.

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо

Төгрөгийн худалдан авах чадвар сайжирч байгаа нь эх үүсвэрийн долларжилт буурахад нөлөөллөө.

Төгрөгийн ханш харьцангуй тогтвортой байсан нь төгрөгт итгэх итгэлийг нэмэгдүүллээ.
Долларын эх үүсвэр аажмаар буурч байна.



БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2025 он

Банкны актив буюу хөрөнгө

Жич: Банкны нийт өр төлбөр дээр нэмэх нь эздийн өмчийг бүхэлд нь банкны хөрөнгө буюу актив гэнэ.

Системийн нөлөө бүхий
банкуудын актив


18%

ӨСӨВ.

Банкны системийн нийт актив өмнөх оны мөн үеэс 11.4 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Голомт банкны актив 23хувиар, ХХБ-ны актив 21 хувиар, Хаан банкны актив 18 хувиар тус тус өсжээ. Хасбанкны актив 9 хувиар, Төрийн банкны актив 8 хувиар тус тус нэмэгджээ.


Банкнуудын актив жил бүрийн IV улиралд



Банкны салбарын нийт эх үүсвэр өмнөх онтой харьцуулахад 3.9 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

ХХБ-ны эх үүсвэр 1.5 их наяд төгрөгөөр, Голомт банкны эх үүсвэр 1.3 их наяд төгрөгөөр нэмэгджээ.
Хаан болон Хас банкны эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэмэгджээ.

Банкнудын эх үүсвэр жил бүрийн IV улиралд



2023	2024	2025
Хаан		
2023	2024	2025
ХХБ		
2023	2024	2025
Голомт		
2023	2024	2025
Төрийн банк		
2023	2024	2025
Хас		

Банкны эх үүсвэр

Жич: Иргэд, байгууллага болон хөрөнгө оруулагчдаас татсан өр төлбөрийн хэмжээ.

Банкуудын эх үүсвэр

10%

нэмэгджээ.

Өөрийн хөрөнгийн өгөөж

Жич: Тухайн байгууллага нь өөрийн хөрөнгөө хэр үр ашигтай зарцуулж буй тухай мэдээлэл өгдөг. Өөрөөр хэлбэл компани хөрөнгийг хэрхэн ашиг болгож буйг илэрхийлдэг үзүүлэлт юм.

Банкуудын өөрийн
хөрөнгийн өгөөж дунджаар


19%

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

Банкуудын өөрийн хөрөнгийн өгөөж хадгаламжийн өгөөжөөс өндөр байна.

Системийн нөлөө бүхий банкуудын өөрийн хөрөнгийн дүн 7.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 15 хувиар өсжээ. Өөрийн хөрөнгөөр бий болгосон ашгийн хэмжээ өндөр байна.


Банкнудын өөрийн хөрөнгийн өгөөж, жил бүрийн эцэст



Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ хангалттай байна.

Банкуудын зээлийн өсөлт нь өөрийн хөрөнгийн хүрэлцээг бууруулсан хэдий ч эдийн засгийн өсөлтийг цаашид дэмжих, гол салбаруудын идэвхжилийг нэмэгдүүлэхэд хангалттай өөрийн хөрөнгөтэй байна.

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ, жил бүрийн IV улирал



2023	2024	2025
Хаан		
2023	2024	2025
ХХБ		
2023	2024	2025
Голомт		
2023	2024	2025
Төрийн банк		
2023	2024	2025
Хас		

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Жич: Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлсон үнэлгээг хэлдэг.

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний дундаж

17%

Хөрвөх чадварын харьцаа

Жич: Богино хугацаат төлбөрүүдийг цаг тухайд
нь төлөх чадварыг хэмждэг харьцаа.

Системийн нөлөө бүхий
банкуудын хөрвөх чадварын
харьцаа үзүүлэлтийн дундаж


38.6%

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

Системийн нөлөө бүхий таван банкны хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт өндөр хэвээр байна.

Бизнес эрхлэгчдэд олгож буй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад өсөлттэй байна.
Зээлийн хэмжээ тасралтгүй өссөн ч банкууд хангалттай хэмжээний хөрвөх чадвартай байна.

Банкнуудын хөрвөх чадварын харьцаа, жил бүрийн IV улирал



2023	2024	2025
Хаан	ХХБ	Голомт
Төрийн банк	Хас	

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

2025 онд: Эдийн засгийн өсөлт 6.8 хувьтай гарлаа. Хөдөө аж ахуйн салбарын сэргэлт нь эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чухал нөлөө үзүүлээ. Уул уурхайн салбар түүнийг дагасан тээвэр, логистик, үйлчилгээний салбар харьцангуй тогтвортой байгаа нь эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Боловсруулах болон барилгын салбар аажмаар өсөж буй нь эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлээ.

Төлөв байдал: Манай улсын хувьд уул уурхайн бус салбар тэр дундаа барилга, боловсруулах болон ХАА-г дэмжих чиглэлээр дэд бүтцийн ажлуудыг эрчимжүүлэх хэрэгцээ, шаардлага улам бүр нэмэгдэж байна. Экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн уул уурхайн гаралтай бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх, нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын арга хэмжээг авах замаар уул уурхайн бүтээгдэхүүнийг төрөлжүүлэхэд анхаарах хэрэгцээ шаардлага өндөр байна. 2026 онд уул уурхайн гаралтай түүхий эдийн экспортоос олох орлогыг өндрөөр төсөөлж төсвийн зардлыг нэмэгдүүлсэн нь макро эдийн засгийн тогтвортой байдалд эрсдэл дагуулж байна.


Эдийн засаг 2025 онд 6.8 хувиар өсөв.

Удаан хугацааны дараа хөдөө аж ахуйн салбар эрчимтэй сэргэж байгаа нь эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө үзүүллээ.

Уул уурхайн салбар болон түүнийг дагасан тээвэр, логиستيкийн салбарын өсөлт үргэлжилж байгаа нь эдийн засаг тэлэхэд чухал нөлөө үзүүллээ.

Худалдаа, үйлчилгээний салбарын өсөлт нь эдийн засгийн өсөлтийг дэмжлээ.

Боловсруулах үйлдвэр болон барилгын салбар аажмаар сэргэж байгаа нь эдийн засгийн өсөлтийг дэмжлээ.






Гадаад худалдааны тэнцэл өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар нэмэгджээ.

Эрдэс бүтээгдэхүүн түүний дотор зэсийн баяжмал, хагас боловсруулсан алт, цайрын хүдрийн баяжмал экспортын өсөлтөд чухал нөлөө үзүүлжээ. Нүүрсний тоо хэмжээ нэмэгдсэн ч үнэ буурснаас шалтгаалан экспортын хэмжээ буурчээ. Машин тоног төхөөрөмж, суудлын авто машин болон нефтийн бүтээгдэхүүний худалдан авалт буурсан нь импорт буурахад нөлөөлжээ.

Зэсийн хүдэр, алт, цайрын баяжмалын нийлүүлэлт нэмэгдсэн нь **экспортын өсөлтийг** дэмжлээ.

Нефтийн бүтээгдэхүүний **импорт буурчээ.**

Гадаад худалдааны тэнцэл ашигтай байна.




Төлбөрийн тэнцэл 1 тэрбум ам.долларын ашигтай гарч төгрөгийн ханшид ирэх дарамт бага байна.

Манай улсын тээврийн үйлчилгээ, аялал жуулчлалын орлого нэмэгдсэн нь урсгал дансны алдагдлыг бууруулжээ.


Гадаадын хөрөнгө оруулалт буурсан ч санхүүгийн данс ашигтай байна.

Төгрөгийн бодит ханш чангарч манай улсын бараа, бүтээгдэхүүн бусад улстай харьцуулахад үнэтэй болж байна.

Төгрөгийн нэрлэсэн болон бодит үйлчилж буй ханш



Төлбөрийн тэнцэл



Төсвийн тэнцэл 1.2 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа.


2025 оны эхнээс уул уурхайн гаралтай бүтээгдэхүүнээс олох орлого тасарсан нь төсөв алдагдалтай гарахад нөлөөллөө.

Төсвийн урсгал зардал өндөр байгаа нь төсөвт дарамт учруулсан хэвээр байна.


Сүүлийн 3 жил үндсэн тэнцэл ашигтай гарсан ч төсвийн урсгал зардал хэт өндөр байна.

Төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 4 нэгж хувиар нэмэгджээ.


ДНБ-д эзлэх хувиар



Төсвийн зарлага өмнөх оноос 3 нэгж хувиар буурчээ.



Үндсэн тэнцэл ашигтай байна.



Гадаадын хөрөнгө оруулалтыг татахад эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлага өндөр байна.

- Банкны тухай хуулийн хэрэгжилтийг хангахад 2 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалт буюу Монгол Улсад орж буй нийт гадаадын хөрөнгө оруулалтын $\frac{1}{4}$ тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байна.
- Хөрөнгө оруулалт татахад суутган татварын хэмжээг бууруулах, татварын давхардлыг арилгах шаардлагатай байна.
- Хөрөнгийн үнийн өсөлт болон бууруултаас авах татварын хэмжээг оновчтой тодорхойлох шаардлагатай байна.

Монгол Улсын хувьд гадаадын хөрөнгө оруулалтыг татахад татварын орчинг тодорхой болгох хэрэгцээ шаардлага өндөр байна.

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024	2025
Зээлжих зэрэглэл	В3 тогтвортой	В3 тогтвортой	В3 тогтвортой	В3 тогтвортой	В2 тогтвортой	В1 тогтвортой
Авлигын индекс	35	35	33	33	33	31
Инновацийн индекс	58	58	71	68	67	78
Өрсөлдөх чадварын индекс	61	60	61	62	61	65

^[1] Moody's агентлагийн гаргасан зэрэглэлийг авч үзэв.

^[2] <https://www.transparency.org/en/>

^[3] Global Innovation Index 2025

^[4] IMD world competitiveness